



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/463

Арвайхээр


Түр хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "л", 29.2, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуулийн санал авах өдөр буюу 2020 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн "Пүрэв" гарагт аймгийн хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, мөн худалдаа үйлчилгээний төвүүд гадаа болон битүү талбай (зах)-д үйл ажиллагаа явуулахыг түр хориглосугай.

2.Дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний цэгүүдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (О.Ганбат), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011101025